

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН СУВИЛАГЧДЫН АЖЛЫН БАЙРНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

Сэдэд Оюунгэрэл^{1*}, Цэрэндорж Оюундарь²,

Сувилахуйн Ухааны Тэнхим

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

*Цахим хаяг: Oyungerel.se@monos.mn

JOB SATISFACTION AMONG NURSES IN FAMILY HEALTH CENTER

Oyungerel Seded^{1*}, Oyundari Tserendorj²,

Department of Nursing

Mongolian University of Pharmaceutical Sciences

*Email: oyungerel.se@monos.mn

Abstract

Introduction: The job satisfaction of family health center nurses, and the factors affecting it, directly affect the stability of the nursing workforce and the quality and performance of their work. This in turn impacts nursing care provided to family clients of all ages. It is important to value nurses' work, productivity, and job satisfaction with certain periodicity to improve the nursing management system.

Aim: To determine the job satisfaction of family health center nurses.

Methods: A descriptive cross-sectional design was used for the study. 102 nurses from family health centers participated in the survey. The Nurse's satisfaction instrument (The American Nursing Associations' "Satisfaction of Nurses", 2021) has 43 items, and 3 subscales (nurses satisfaction, influencing factors for nurses' satisfaction, and possible solutions). The nurse's satisfaction was rated as poor <0-60, average <61-122, and good <123-180 points. Questions were collected on paper from December 2022 to March 2023. The survey took 15-20 minutes to complete.

Results: The job satisfaction of family health center nurses is at a good level (131.98±13.06). Considering the results of the subgroups, the nurse satisfaction group was (mean=32.8±4.06) average, the factors affecting nurse satisfaction were (mean=58.6±8.05) good, and the possible solutions were (mean=40.4±3.04) indicating agreed. There were results that nurses' workload, professional value, salary, and human resources are the most important factors affecting for job satisfaction of nurses.

Conclusion: According to the research, there is a need for an integrated policy program to improve the job satisfaction of family health center nurses and the factors affecting it.

Keywords: Job satisfaction, family health center, nurse.

Судалгааны ажлын үндэслэл

Сувилахуй нь эрүүл мэндийн салбарын хамгийн том мэргэжлийн бүлэг бөгөөд сувилагч нар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 60 хувийг бүрдүүлдэг, ур чадвар, энэрэнгүй сэтгэл, үнэнч шударга, тэвчээртэй байдлыг шаарддаг дэлхий дахинд хамгийн эрхэм мэргэжлүүдийн нэг юм.¹ (ДЭМБ 2020) Монгол улсын хувьд нийгмийн эрүүл мэндийн сувилагч нь тосгоны эмнэлэг, өрх, сум, сум дундын эмнэлгийн сувилагч хэмээн төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод (2017) тусгасан байна.²

Анх нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, төр болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын түншлэлийг дэмжих зорилгоор

эрүүл мэндийн салбарт өрхийн эмнэлгүүдийг зохион байгуулснаас хойш өнөөдөр өрхийн эрүүл мэндийн төв болон хөгжлийн тодорхой шатанд хүрч, үйл ажиллагаа нь улам өргөжин иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний цар хүрээгээ нэмэгдүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ тогтолцоо бүрэлдэн бий болсноор, иргэд маань өрхийн эмч, сувилагчаа эн тэргүүнд зорьж, шаардлагатай тусламж үйлчилгээгээ шуурхай авах болсон нь том ололт билээ.³ (МӨАУМХ-ны ерөнхийлөгч профессор С.Сонин, 2015)

Улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 2101 хүн ноогдож өрхийн эрүүл мэндийн төвийн эмч сувилагчийн харьцаа 1:0.9⁴ (ЭМХ үзүүлэлт 2021) байгаа нь улсын дунджаас доогуур,

нийт хүн амын 48,1% нь оршин сууж буй нийслэлд бүх нийтийн эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын ачаалал, хүний нөөцийн дутагдалыг үүсгэж байгаа нь ажлын байрны сэтгэл ханамжид тулгарч буй сорилт юм.

Иймд өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй сувилагчийн ажлын үнэлэмжийг сайжруулах, эрүүл ажлын орчинг бүрдүүлж, нийгмийн эрүүл мэндийн чанартай тусламж, иргэдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхэд өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг судлах үйл ажиллагааны шаардлага сувилахуйн удирдлагын тулгамдсан асуудал болж байгаа нь судалгааны үндэслэл боллоо.

Судалгааны зорилго

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг тодорхойлох

Судалгааны зорилт

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг судлах

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчийн ажлын байрны сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох

Судалгааны материал арга зүй

Судалгааг нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн зүүн захын Баянзүрх болон төвийн Баянгол дүүргийн нийт 26 өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдыг түүврийн баазаар түшиглэн, түүврийн хүрээг Японы эрдэмтэн Таро Ямано-н боловсруулсан томъёогоор тооцоолж 102 сувилагчийг сонгон зорилтот түүвэрийн аргаар судалгаанд хамруулахад дутуу бөгөлсөн 2 сувилагчийг хасан 100 сувилагч хамрагдав.

Судалгааны хэрэглэгдхүүн: Америкийн сувилагчийн нийгэмлэгийн “Сувилагч нарын өнөөгийн байдал” судалгааны 3 бүлэг 36 асуулттай сэтгэл ханамжийн асуулгаар мэдээлэл цуглуулсан. Статистик боловсруулалтыг SPSS-23 програм ашиглан боловсруулав. Асуумжийн найдвартай байдлын кронбахын альфа 0,85 байв.

Table 1. Interpretation of the level of assessment scores for each group of the Nurses' Job Satisfaction Questionnaire.

Score level			
	Bad	Average	Good
Nurse's job satisfaction	<0-17	<18-33	<34-50
Factors affecting nurse satisfaction	<0-26	<27-52	<53-80
Possible solution	<0-17	<18-33	<34-50
Overall satisfaction survey	<0-60	<61-122	<123-180

Судалгааны үр дүн

Бид судалгааг 2022 оны 12 сараас 2023 оны 04 сарын 01 өдрийн хооронд Нийслэлийн

2 дүүргийн өрхийн сувилагчаар ажиллаж буй сувилагч нараас сонгон авч гүйцэтгэв.

Table 2. Sociodemographic information

		N	%	SD±M
Gender	Female	96	96.2	0.45±1.28
	Male	4	3.8	
Age	22-30	15	15	1.48±3.20
	31-40	23	24	
	41-50	28	27.4	
	51-55	24	24.2	
	Over 56	10	9.4	

Education level	Bachelor	44	44.2	1.01±2.90
	Diploma	56	55.8	
	Master's degree	0	0	
Years of service in the country	1-5	14	17	1.85±3.49
	6-10	10	9.4	
	16-20	5	4.7	
	21-25	13	12.3	
	Over 26	31	29.2	
	11-15	27	27.4	
Years of work at the Family Health Center	1-5	47	49	1.77±2.75
	11-15	13	12.3	
	16-20	11	10.4	
	21-25	10	9.4	
	Over 26	4	3.8	
	6-10	15	14.2	
Position	Senior nurse	13	17.9	1.27±2.40
	Junior nurse practitioner	5	4.7	
	Vaccine nurse	15	14.2	
	Laboratory nurse	4	3.8	
	Family health center nurse	63	59.4	
Workplace	Bayanzurkh district	54	57.5	2.352±1.254
	Bayangol district	46	42.5	

Судалгаанд оролцсон сувилагчдын: Хамгийн залуу нь 23 нас($n=10$), хамгийн ахмад нь 60 ($n=2$), Дундаж нас нь 41-50(27.4%), дипломын боловсролтой 56(55.8%), Эмэгтэй 96,2%(96) дийлэнх нь, улсад ажилласан

жилээр 26-аас дээш жил ажилласан 29,2 хувь, өрхийн эрүүл мэндийн төвд ажилласан хамгийн их 49% нь 1-5 жил ажилласан ба 59,4 % буюу ихэнх нь өрхийн сувилагч албан тушаалтай сувилагч нар хамрагдав.

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн үр дүн

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын (16 зүйл), боломжит шийдэлийг (10 зүйл) ажлын байрны сэтгэл ханамжыг (10 зүйл), асуулгаар шинжилгээ хийхэд дараахь сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг байдлаар дүгнэжээ. Хүснэгт 3, 4, 5-т харуулав.

Table 3.($n=100$). Results of survey on job satisfaction of family health center nurses

Variable	%	SD±M
Are you satisfied with your current job	45 (45.0)	3.47±1.259
I want to stay at my job, but I need to make a change	47 (47.0)	3.45±1.123
How to comply with support and service standarts	40 (40.0)	2.74±1.522
About organizational culture, teamwork and unity	15 (15.0)	3.94±1.003
The reputation of the nursing profession	48 (48.0)	2.75±1.438
Workplace comfort,rest room and cafeteria	24 (24.0)	3.51±1.273
Our supervisor appreciates and praises my work	31 (31.0)	3.33±1.155
Nurses have opportunites for advancement and success	46 (46.0)	3.24±1.450
Salary and bonuses	41 (41.0)	3.05±1.513

Quality and safety of nursing care	26 (26.0)	3.18±1.329
ОНОО-32.6	P>0.003	

Судалгаанд оролцогч сувилагч нар нь ерөнхий сэтгэл ханамж 32,6 буюу дунд түвшинд (<18-33) P>0.003 статистик ач холбогдолдтой гарлаа. Та одоо байгаа ажилдаа сэтгэл ханамжтай байдаг уу (45.0%), ажилдаа үлдэхийг хүсэж байгаа ч

өөрчлөлт хийх шаардлагатай (47.0%), сувилагч мэргэжлийн нэр хүнд (48.0%), сувилагчид албан тушаал ахиж, амжилт гаргах боломж байдаггүй (46.0%) хэмээн илэрч байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Table 4. (n=100). Overall results of the three groups of job satisfaction questionnaires for family health center nurses

	Low value	Great value	Average	SD±M	Level / in points /
Nurses' satisfaction	22	48	32.8727	4.06242	Average /18-33/
Factors affecting nurse satisfaction	42	77	58.6593	8.05291	Good and agreed /34-50/
Possible solution	18	31	40.4505	3.04873	Good and completely agree
Overall satisfaction	108	151	131.9825	13.06739	Satisfied

Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын оноо нь 131.98±13.06 буюу сэтгэл ханамж ажлын байрны сэтгэл ханамжийн нийт дундаж сайн түвшинд байна.

Table 5. Results identifying factors influencing job satisfaction of family health center nurses.

		Age	Education	Years of work at the Family Health Center	Nurse satisfaction
Age	Pearson Correlation	1	.692**	.484**	.645**
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.000
	N		100	100	100
Education	Pearson Correlation		1	-.312**	-.306**
	Sig. (2-tailed)			0.000	0.003
	N			100	100
Years of work at the Family Health Center	Pearson Correlation			1	.575**
	Sig. (2-tailed)				0.000
	N				100
Nurse satisfaction	Pearson Correlation				1
	Sig. (2-tailed)				
	N				

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Table 6. (n=100). The dependent variable is the nurse's job satisfaction

	B	Beta	t	Sig.
Age	1.452	.645	4.566	.000
Education	-6.251	-.306	-3.020	0.003
Years of service	1.131	.575	5.308	.000

R²=.084 (Нас= 0.645, боловсрол=-0.306, ажилласан жил =0.575)

Сувилагчдын боловсролын түвшин нь ажлын сэтгэл ханамжид сөрөг ба дунд зэргийн, нас, ажилласан жил нь эерэг хамааралтай, боловсрол чухал нөлөөтэй 8% сэтгэл ханамжийг төлөөлж буй таамаглагч хувьсагч болж байна. Боловсролын түвшин нэмэгдэхэд сэтгэл ханамжийн түвшин буурч, нас, ажилласан жил нэмэгдэхэд ажлын байран дээрх сэтгэл ханамж 1,452 нэмэгдэхээр байна.

Table 7. (n=100)

	Unstandardized Coefficients		Standardized Coefficients		
Model	B	Std. Error	Beta	t	Sig.
(Constant)	1.768	.754		2.346	.021
* I feel like the workload is too much.	.558	.214	.373	2.601	.011
* How valuable do you think the nursing profession is?	.293	.119	.312	2.471	.015
* Do you think it is necessary to enroll in the nursing profession?	.064	.120	.067	.533	.595
* I felt that I was very underpaid.	.733	.223	-.460	-3.290	.001

Dependent Variable: Өрхийн сувилагчийн сэтгэл ханамж

Ажлын ачаалал маш их юм шиг санагддаг хэмээх хувьсагч 0.5 нэгжээр нэмэгдэхэд сувилагчийн сэтгэл ханамж 0.558 нэмэгдэнэ. Сувилагч мэргэжлийн үнэлэмж өсөхөд сувилагчийн сэтгэл ханамж 0.293 сайжирна. Мөн цалингийн хэмжээ нэг нэгжээр өсөхөд сувилагчийн сэтгэл ханамж 0.733 нэгжээр сайжирах нөлөөтэй хүчин зүйлээр илэрлээ.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан дүүргүүдийн өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн ерөнхий сэтгэл ханамж сайн (131.98±13.06), сувилагчийн сэтгэл ханамж дэд бүлэг 32.8±4.06 буюу дунд түвшинд хэмээн илэрлээ. Энэ нь төр засагаас сүүлийн жилд анхан шатанд бүх насны хүн амд нийгмийн эрүүл

мэндийн тусламж үйлчилгээ хүргэдэг өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг дэмжих бодлого баримталж нэг иргэнд ногдох санхүүжилтийг нэмсэнтэй уялдаж байна.

2. Сувилагчийн ажлын байрны сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийн бүлэг 58.6±8.05 буюу санал нийлсэн үр дүнтэй гарч үл хамааралт хувьсагчууд нас, ажилласан жил нэмэгдэхэд сувилагчийн ажлын байрны сэтгэл ханамж нэмэгдэж, боловсролын түвшин дээшилхэд сувилагчийн ажлын байрны сэтгэл ханамж буурч, боловсрол маш чухал нөлөөтэй 8% сэтгэл ханамжийг төлөөлж буй таамаглагч хувьсагч хэмээн илэрч байгаа нь сувилагч нар боловсролоо дээшлүүлж бакалавр,

магистр болсноор цалингийн шатлалд өөрчлөлт ордоггүйтэй холбоотой гэж үзлээ. Мөн ажлын ачаалал маш их юм шиг санагддаг хэмээх хувьсагч 0.5 нэгжээр нэмэгдэхэд сувилагчийн сэтгэл ханамж 0.558, цалингийн хэмжээ нэг нэгжээр өсөхөд сувилагчийн сэтгэл ханамж 0.733 нэгжээр тус тус сайжирах гол нөлөөтэй хүчин зүйлүүд илэрч байна.

3. Судалгааны дэд бүлэг боломжит шийдэлийн дундаж оноо 40.4 ± 3.04 бүрэн санал нийлсэн байгаа нь цаашид өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч нарын ажлын байрны сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг сайжруулах нэгдсэн бодлогын хөтөлбөр шаардлагатай байна.

Ном зүй

1. Shir Gi Toh RN BHS (Nursing) (Hons), 1, 2, 3., et al. (2013) Systematic review on the relationship between the nursing shortage and job satisfaction, stress and burnout levels among nurses in oncology/hematology settings. *Int J Evid Based HealthcHealth Affairs*, 10: 126–141.
2. Khamisa, N., Peltzer, K., Ilic, D., & Oldenburg, B. (2016). Work-related stress, burnout, job satisfaction and general health of nurses: A follow-up study. *International Journal of nursing practice*, 22(6), 538-545.
3. Nurse.org.State of Nursing Report (2022) Nurse.org
4. Aziz Shamsi, Hamid Peyravi. 2020. Feb 19. Nursing shortage, a different challenge in Iran: A systematic review. doi 10.34171/Jiri.34.8
5. Halcomb, E., & Ashley, C. (2017). Australian primary health care nurses most and least satisfying aspects of work. *Journal of clinical nursing*, 26(3-4), 535-545.
6. Curtis, E. A., & Glacken, M. (2014). Job satisfaction among public health nurses: a national survey. *Journal of nursing management*, 22(5), 653-663.
7. У Га Шил, Сувилахуйн судалгааны арга зүй, 2020
8. Оюундарь, Өрхийн эмнэлгийн сувилагчийн ажлын ачаалал
9. Энхжаргал Я. Сувилахуйн судалгаа. Мөнхийн үсэг ХХК.УБ., 2020
10. Монгол улсын өрхийн эрүүл мэндийн төвийн стандарт. MNS:5292, 2017
11. НЭМГ Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэчлэл, 2015
12. Басбиш, Судалгааны статистик боловсруулалт, 2020
13. Хулан, RN, PhD, Дэлхийн Эрүүл Мэнд ба Бодлого -Global Health & Policy
14. Legalinfo.mn “Нийгмийн эрүүл мэндийн тухай төрөөс баримтлах бодлого”
15. 1212.mn /Үндэсний статистикийн хороо/ “нийслэлээр”